



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар “Журам батлах тухай” тушаалын 18.9, 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, 2021 оны Б/08 дугаартай “Албан үүрэг түр орлон гүйцэтгүүлэх тухай” тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл тусламжийн ашиглалт үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын /АГГ-2021/10-ШТА-ГА/ тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангуулж, дүнг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумьяабазар/-д зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Аудитын гуравдугаар хэлтсийн дарга, аудитын менежер /Э.Мөнхмандах/-д үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ




М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР





ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот
2021 он



Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	3
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт	4
Аудитын Гуравдугаар хэлтэс		
Хэлтсийн дарга, аудитын менежер	Хавсралтын жагсаалт	4
 Э.Мөнхмандах		
Аудитын менежер	Графикийн жагсаалт	4
 Б.Номинбаатар		
Ахлах аудитор	Ерөнхий зүйл	5-6
 Ж.Жавзанпагма		
Аудитор	Ерөнхий мэдээлэл	7-8
 М.Одгэрэл	БҮЛЭГ А.	
 О.Дашхонгор	Засгийн газрын шугамаар олон улсын байгууллагаас авсан зээлийг үр дүнтэй ашигласан уу?	9-23
	Бүлэг Б.	
2021 оны 05 дугаар сарын 10	Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн ашиглалт үр дүнтэй байна уу?	24-32
Уг тайланг НТАГ-ын https://niislel.audit.mn/web сайтаас үзнэ үү.	Дүгнэлт	33
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 327787 утсаар харилцана уу.	Зөвлөмж	34
	Холбогдох байгууллагын санал	35
	Саналд өгсөн тайлбар	36
ХАЯГ: Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хавсралт	37-38
Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө Г корпус		



Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
ХЭЗХАХЯ	Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн яам
АХБ	Азийн хөгжлийн банк
ЕХОБ	Европын оруулалтын банк
ЕСБХБ	Европын сэргээн босголт хөгжлийн банк
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ОУХА	Олон улсын хөгжлийн агентлаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УБ	Улаанбаатар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НАЗХГ	Нийслэлийн автозам хөгжлийн газар
НӨАУГ	Нийслэлийн өмч ашиглалт, удирдлагын газар
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ТХХЗХ	Төсөл хөтөлбөр хяналт зохицуулалтын хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ТУХ	Төслийн удирдах хороо
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ
ОУБ	Олон улсын байгууллага
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ХХ	Хөгжлийн хөтөлбөр



Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар нийслэлд хэрэгжүүлж буй ТАХ	7
Хүснэгт 2	ТАХ салбарын бодлогын баримт бичигт уялдсан эсэх тооцоолол	10
Хүснэгт 3	ТАХ шаардлагад заасан баримт бичиг	13
Хүснэгт 4	Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний хэрэгжиж буй хугацаа	14
Хүснэгт 5	ТАХ-ний хэрэгжилтийн явцад бий болсон хөрөнгийн жагсаалт	15
Хүснэгт 6	ТАХ-ний төслийн хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц орон тоо	17
Хүснэгт 7	Дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөгдөх үндсэн болон хүүгийн дүн	19
Хүснэгт 8	Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжаар хэрэгжиж буй төслийн жагсаалт	24
Хүснэгт 9	Шаардлагатай баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлсэн ТАХ	25
Хүснэгт 10	Буцалтгүй тусламжаар нийлүүлсэн хөрөнгийн жагсаалт	28
Хүснэгт 11	Шилэн дансны мэдээлэл	31

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байдал	37
Хавсралт 2	Шилэн дансны мэдээлэл	37
Хавсралт 3	Бодлогын баримт бичигт нийцсэн байдал	38

График жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
График 1	Төсөл хэрэгжүүлж буй салбар	9
График 2	ТУХ, ТХН байгуулсан байдал	16
График 3	Төсөл хэрэгжүүлж буй салбар	24



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газрын гүйцэтгэх аудитын сэдэв, Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийв. Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: ✚ Засгийн газрын шугамаар олон улсын байгууллагаас авсан зээлийг үр дүнтэй ашигласан эсэх; ✚ Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн ашиглалт үр дүнтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Нийслэлийн ЗДТГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Төсөл, хөтөлбөрийн хяналт зохицуулалтын хэлтэс, Нийслэлийн авто зам хөгжлийн газар, Ус сувгийн удирдах газар, Төслийн хяналтын нэгжүүд болон бусад холбогдох байгууллагын 2018-2020 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн батлуулсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгаар зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, АДБОУБ (INTOSAI)-ын 5250 Улсын өрийн удирдамж, арга зүйд нийцүүлэн, Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудит хийх аргачлалд заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт



боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад дараах эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

➤ Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт, Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”, Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам” болон аудитын зорилго, зорилтод шаардагдах бодлогын болон хууль эрх зүйн бусад баримт бичгүүд



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Нийслэлд Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас 2018-2020 онд хөнгөлөлттэй зээлээр 497.8 сая USD, 88.7 сая EUR-ийн санхүүжилттэй 11 TAX, буцалтгүй тусламжаар 67.7 сая USD, 3.6 сая EUR, 4.8 сая CHF-ийн санхүүжилттэй 9 TAX нийт 565.7 сая USD, 92.3 сая EUR, 4.8 сая CHF гадаад валютын TAX хэрэгжиж байна.

Хүснэгт 1. Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар нийслэлд хэрэгжүүлж буй TAX

№	Гэрээний тоо	Санхүүжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Санхүүжилт	Валют	Эхэлсэн огноо	Дуусах огноо
Хөнгөлөлттэй зээл							
1	1	ДБ-ны ОУХА	Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл	12.0	USD	2020	2021
	2	ДБ	Улаанбаатар цэвэр агаар төсөл	15.0	USD	2012	2019
2	3	АХБ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл 1(Энгийн үйл ажиллагаа)	27.5	USD	2014	2021
	4	АХБ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл 1(Тусгай үйл ажиллагаа)	22.5	USD	2014	2021
	5	АХБ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл-2	37.1	USD	2017	2022
	6	АХБ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл-2	21.5	USD	2017	2022
	7	ЕХОБ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	21.0	EUR	2014	2021
	8	ЕХОБ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	29.0	USD	2014	2019
3	9	АХБ	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	60.0	USD	2019	2027
	10	АХБ	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	20.0	USD	2019	2027
4	11	Австри	Усны шугам сүлжээг шуудуу ухалгүйгээр сэргээн засварлах технологи нэвтрүүлэх төсөл	7.0	EUR	2017	2024
5	12	БНХАУ	Замын цагдаагийн газрын дэргэдэх уулзварт гүүрэн гарц байгуулах төсөл	42.4	USD	2016	2021
6	13	БНХАУ	Яармагийн шинэ гүүр барих болон хуучин гүүрийг сэргээн засварлах төсөл	30.3	USD	2016	2021
7	14	БНХАУ	Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл	21.4	USD	2018	2021
8	15	БНХАУ	Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл	34.7	USD	2019	2021
9	16	ЕСБХБ	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл	9.7	USD	2018	2022
10	17	Франц	Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл	60.7	EUR	2020	2023
11	18	БНСУ	Баянголын амны 2007 айлын орлогд нийцсэн орон сууц барих төсөл	114.7	USD	2020	2024
Буцалтгүй тусламж							



12		АХБ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	3.7	USD	2014	2019
3		АХБ	Гэр хорооллын нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл	2.0	USD	2020	2023
14		АХБ	Улаанбаатар хотын орлогд нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бийх хотын шинэчлэл салбарын төсөл	53.0	USD	2019	2027
15		АХБ	Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл	3.0	USD	2020	2023
16		КОЙКА ОУБ	Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв, инкубатор төсөл-2	1.3	USD	2016	2020
17		ШХА	Хотын Засаглалыг Сайжруулах Төсөл	4.8	CHF	2015	2022
18		НҮБ-ийн ХХ	Улаанбаатар хотод тогтвортой хөгжлийн зорилгуудыг нутагшуулах санаачилга	0.4	USD	2017	2021
19		ХБНГУ-ын ХЭДХАХЯам, ШХА	Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл	3.6	EUR	2018	2021
20		ЖАЙКА ОУБ	Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл - 3	4.2	USD	2018	2023

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 11 ТАХ-г хэрэгжүүлэхээр 18 зээлийн гэрээ байгуулагдсанаас 8 ТАХ-ний 9 гэрээг Сангийн яам санхүүжүүлэгч байгууллага хооронд, 3 ТАХ-ний 9 гэрээг Нийслэлийн ЗДТГ, Сангийн яам хооронд дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулжээ.

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 9 ТАХ-ээс Азийн сангаас хэрэгжүүлж буй Койка ОУБ-ын санхүүжилттэй “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв, инкубатор төсөл-2”, ШХА-аас санхүүжилттэй “Хотын засаглалыг сайжруулах төсөл”, НҮБ-ийн ХХ-өөс санхүүжүүлж буй “Улаанбаатар хотод тогтвортой хөгжлийн зорилгуудыг нутагшуулах санаачилга төсөл”-ийг донор орноос хэрэгжүүлдэг учир аудитад хамруулаагүй болно.

Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжаар хэрэгжиж байгаа 17 ТАХ-ээс 7 ТАХ эхлэлийн үе шатанд, 8 хэрэгжих шатанд, 2 ТАХ-ний 1 үе шат хэрэгжиж дуусаад Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай” тогтоолоор “Цэвэр агаар” нэмэлт санхүүжилтийн төслийг баталснаар хугацаа сунгагдсан байна.




БҮЛЭГ А. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТАХ НЬ БҮРЭН ДУУСААГҮЙ, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЖ ҮР НӨЛӨӨГ ТООЦООГҮЙ УЧИР ЗЭЭЛИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАСАН ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Нийслэлийн хэмжээнд 2018-2020 оны байдлаар Монгол улсын Засгийн газрын түншлэгч орон, олон улсын байгууллагуудтай хамтран хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 11 ТАХ-ны 479.8 сая USD, 88.7 сая EUR санхүүжилттэй төсөл хэрэгжиж байна.

Хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-г салбараар нь авч үзвэл байгаль орчин, барилга хот байгуулалт, авто замын салбаруудад хэрэгжиж байна. Үүнийг графикаар харуулбал:



Төсөл хэрэгжүүлж буй салбар
/График 1/

Хэрэгжүүлж буй ТАХ-ний ажлын гүйцэтгэл нь 30%-с доош хэрэгжилттэй 5 төсөл, ажлын гүйцэтгэл нь 70% дээш хэрэгжилттэй 6 төсөл байна.

А.1 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-г тухайн салбарын болон Нийслэлийн хөгжлийн бодлогуудтай уялдуулж, зээлийг сонгон шалгаруулж олгосон ч дамжуулан зээлдүүлэх гэрээг шаардлагад нийцүүлж сонгон шалгаруулаагүй байна.

А.1.1 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний зорилго, зорилт нь Засгийн газар, салбарын бодлого төлөвлөлт болон Улаанбаатар хотын хөгжлийн хөтөлбөр, Нийслэлийн ЗД-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн салбарт төрөөс баримтлах бодлоготой уялдсан байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1¹, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 8.1.1²-д Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ нь Монгол улс, Засгийн газрын урт,

¹6.2.1.Засгийн газар, орон нутгийн зээллэг, Засгийн газрын өрийн баталгаа нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон Улсын Их Хурлаас баталсан урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;

² 8.1.1 “төсөл, арга хэмжээний үйл ажиллагааны төлөвлөлт нь гэрээ, хэлэлцээрт тусгагдсан төслийн зорилт, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх”



дунд хугацааны хөгжлийн бодлого болон салбарын хөгжлийн бодлогуудтай уялдсан байхаар заажээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. ТАХ салбарын бодлогын баримт бичигт уялдсан эсэх тооцоолол

/№	ТАХ нэр	Бодлогын баримт бичгийн нэр	Батлагдсан огноо хэрэгжих хугацаа	Салбарын бодлогын баримт бичигтэй уялдаж буй заалт
1	Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	2017 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталсан. Тус хөтөлбөр нь 2017-2025 онд хоёр үе шаттайгаар хэрэгжиж байна.	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр
2	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл 1	Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичиг	Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан.
3	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	Нийслэлийн 3Д бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан ба тус бодлогын баримт бичиг нь 2016-2020 оны хооронд хэрэгжсэн.	2.3.2 Дагуул, хаяа хот, тосгон, дэд төвүүд, шинэ суурьшлын бүсийг цогцоор нь хөгжүүлж, орлогод нийцсэн орон сууц түрээсийн орон сууцыг хөгжүүлэх, залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. 2.3.3 Орлогод нийцсэн орон сууцыг хөгжүүлэх санхүүгийн тогтвортой механизмыг бүрдүүлнэ.
4	Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл	Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого	2020 оны 03 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан. Тус бодлогын баримт бичгийг 2020-2030 оны хооронд гурван үе шаттайгаар хэрэгжүүлж байна.	2.3.4.3. хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан орон сууцны ашиглалт, засвар үйлчилгээ, инженерийн шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх болон дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх;
5	Замын цагдаагийн газрын ойролцоох уулзварт гүүрэн гарц байгуулах төсөл	Нийслэлийн 3Д бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан ба тус бодлогын баримт бичиг нь 2016-2020 оны хооронд хэрэгжсэн.	2.5.10 Баянзүрх, Яармаг, Сонсголлонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замыг өргөтгөн шинэчлэх
6	Яармагийн шинэ гүүр барих болон хуучин гүүрийг сэргээн засварлах төсөл	Нийслэлийн 3Д бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан ба тус бодлогын баримт бичиг нь 2016-2020 оны хооронд хэрэгжсэн.	2.5.10 Баянзүрх, Яармаг, Сонсголлонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замыг өргөтгөн шинэчлэх
7	Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголлонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл	Нийслэлийн 3Д бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан ба тус бодлогын баримт бичиг нь 2016-2020 оны хооронд хэрэгжсэн.	2.5.10 Баянзүрх, Яармаг, Сонсголлонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замыг өргөтгөн шинэчлэх
8	Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл	Нийслэлийн 3Д бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан ба тус бодлогын баримт бичиг нь 2016-2020 оны хооронд хэрэгжсэн.	2.5.10 Баянзүрх, Яармаг, Сонсголлонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замыг өргөтгөн шинэчлэх
9	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр	2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 298 дугаар Монгол улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан. Тус хөтөлбөрийг 2014-2022 онд	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр 3.1.1 хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглалтыг хөхүүлэн дэмжих



			хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж байна.	
10	Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Монгол улсын Их Хурлын 24 дугаар тогтоолоор батлагдсан. Тус бодлогын баримт бичгийг 2020-2024 оны хооронд хэрэгжүүлнэ.	2.224. Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ.
11	Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл	Нийслэлийн ЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан ба тус бодлогын баримт бичиг нь 2016-2020 оны хооронд хэрэгжсэн.	2.3.2 Дагуул, хаяа хот, тосгон, дэд төвүүд, шинэ суурьшлын бүсийг цогцоор нь хөгжүүлж, орлогод нийцсэн орон сууц түрээсийн орон сууцыг хөгжүүлэх, залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

Дээрх хүснэгтээс харахад 2018-2020 онд хэрэгжиж буй 11 ТАХ нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан 1, салбарын бодлоготой уялдсан 3, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хөгжлийн чиг хандлагын баримт бичигтэй уялдсан 1, Нийслэлийн ЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 8 ТАХ байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ бодлогын баримт бичигтэй уялдаж байгаа нь бодлогын баримтын бичгийн хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлж байна. Төслийн хүрээнд бий болсон үр өгөөжөөс товч дурдвал:

- БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Замын цагдаагийн газрын дэргэдэх уулзварт гүүрэн гарц, Яармагийн шинэ гүүр, Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүр, Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барилгын ажлууд
- Австри Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд УСУГ шинэ техник технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх ажил хийгдсэн бөгөөд үүний үр дүнд богино хугацаанд бусад дэд бүтцийн шугам сүлжээ хөндөлгүйгээр нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хэмнэж хуучин шугам сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулан шинээр шугам сүлжээ бий болгосноор доторлогоо хийгдсэн шугам хоолойн ашиглалтын хугацааг 40 жилээр уртасгасан.
- АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд:
 - 240 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэн 2018 оны 11 дүгээр сард багш хүүхдийн иж бүрэн тавилга, гал тогооны тоног төхөөрөмжийн хамт барилга ашиглагчид хүлээлгэн өгсөн.



- Бизнес инкубатор, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгснөөр 2020 оны 3 сараас үйл ажиллагаагаа эхэлж, 1 давхарт иргэдэд нэг цэгийн үйлчилгээ, 1 болон 2 давхарт иргэдийг чадваржуулах сургалтууд, ажлын байраар үйлчилж байна.

А.1.2 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-г хуульд журамд заасан шаардлагад нийцүүлэн санхүүжүүлжээ.

Өрийн удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1³, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 5.2.1⁴-т Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ нь Монгол улсын төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байхаар заажээ.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих 11 ТАХ-ний санхүүжилтийг Монгол улсын төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд Сангийн сайдын багцад нэгдсэн байдлаар, Засгийн газрын 2019 оны № 290 дугаар “Хөрөнгө батлах тухай” тогтоолд 8 ТАХ тусч, доорх 3 ТАХ тусгагдаагүй байна. Үүнд:

- Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл
- Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл
- Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл

Дээрх ТАХ нь санхүүжүүлэгч оронтой хийх хэлэлцээрийн үед шууд санхүүжигдэхээр батлагдсан учир хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй байна.

Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.5-д “Гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн дотоодын эх үүсвэрийн хэмжээг жил бүрийн төсвийн төсөлд тусгуулах”-аар заажээ.

Аудитад хамрагдаж буй 11 хөнгөлөлттэй зээлийн 18 гэрээнээс Нийслэлийн ЗДТГ болон Сангийн яамны хооронд 3 ТАХ-ний хүрээнд 9 дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулж санхүүжилтийг Нийслэлийн тухайн жилийн төсөвт бүрэн тусгажээ.

Харин 8 ТАХ-ний 9 гэрээ нь Сангийн яам болон санхүүжүүлэгч байгууллагатай байгуулсан тул Нийслэлийн тухайн жилийн төсөвт тусгалгүйгээр санхүүжигдсэн байна.

³ 23.3.1 “энэ хуулийн 18.5.1-18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангасан байх”

⁴ 5.2.1 “Өрийн удирдлагын тухай хуулийн 23.3-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх”



Хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний сонгон шалгаруулах үйл явц нь харилцан адилгүй ялгаатай байдлаар батлагдаж байгаа учир ТАХ-нд тавигдах шаардлагыг төсөл тус бүрийн онцлогт нийцүүлэх нь зүйтэй байна.

А.1.3 Нийслэл, Сангийн яам хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээг шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулаагүй байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5⁵-д дамжуулан зээлдүүлэх гэрээний шаардлагыг тусгажээ.

Нийслэлд 3 ТАХ-ний 9 дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулж санхүүжилтийг Нийслэлийн тухайн жилийн төсөвт бүрэн тусгажээ.

Хүснэгт-3 ТАХ шаардлагад заасан баримт бичиг

№	ТАХ нэр	Дамжуулан зээлдүүлэх гэрээний тоо	ТЭЗҮ батлагдсан эсэх	Эрсдэлийн үнэлгээ тогтоогдсон эсэх	Байгаль орчны нөлөөллийн шинжилгээний хийгдсэн эсэх
1	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл 1, 2	6	Тийм	Тийм	Тийм
2	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	2	Тийм	Үгүй	ТЭЗҮ хамрагдсан.
3	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл	1	Тийм	Үгүй	Хийгдэнэ.

Эх сурвалж: Төслийн нэгжүүдээс ирүүлсэн судалгаа

Аудитын явцад ирүүлсэн судалгааны хүснэгтээс харахад Нийслэлд дамжуулан зээлдүүлэх гэрээ хийгдсэн 3 ТАХ-ээс “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь дамжуулан зээлдүүлэх гэрээний шаардлагад заасан судалгааны баримт бичгүүдийг боловсруулж, үндсэн шалгуур болох эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн талаар мэдээлэл ирүүлсэн боловч эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн эсэх нь баримтаар нотлогдоогүй.

Мөн “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл” нь эрсдэлийн үнэлгээг, “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл” нь эрсдэлийн үнэлгээ, ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй нь Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.5⁶, 18.5.7⁷-д заасныг зөрчсөн байна.

⁵ 29.5 “Засгийн газрын зээллэгийн хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан эцсийн зээлдэгчид зээлдүүлэх тохиолдолд энэ хуулийн 18.5.1-18.5.6, 23.3.3-т заасан шаардлагыг удирдлага болгоно”

⁶ 18.5.5 “адаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлж байгаа тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээ эдийн засгийн үр ашигтай, зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон байх”

⁷ 18.5.7 “тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийгдэж, баталгаажуулсан байх”



А.2 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-г хэрэгжилтийг тодруулж, тулган баталгаажуулалт хийх явцад төслийн хөрөнгийг бүртгэж, үр дүнтэй ашигласан байна. Дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлт хийгдээгүй байна.

А.2.1 Төслийн хүрээнд бий болсон 345,116.6 сая төгрөгийн барилга байгууламж, зам гүүрний барилгыг ашиглалтад оруулж, техник, технологи, тоног төхөөрөмжийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлж, зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.

Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 26.6-д зааснаар ТХН нь ТАХ-ний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгүүлэхээр заажээ.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 11 ТАХ-ээс төслийн баримт бичиг, гэрээнд заасан хугацааны дагуу хэрэгжиж буй 6 ТАХ, гэрээний хугацааг сунгасан 5 ТАХ байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-4 Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний хэрэгжиж буй хугацаа

№	Гэрээнд заасан хугацаандаа үргэлжилж байгаа ТАХ	ТАХ-ний гэрээний хугацааг сунгасан шийдвэр
1	Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл	Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ-ын 2020.04.10-ны өдрийн “Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах” тухай тогтоолоор төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр санхүүжилтийг нэмж баталсан.
2	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр	Төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна.
3	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	Төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна.
4	Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл	Төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна.
5	Замын цагдаагийн газрын ойролцоох уулзварт гүүрэн гарц байгуулах төсөл	Нийслэлийн ЗД-ын 2020 оны А/1126 дугаар захирамж
6	Яармагийн шинэ гүүр барих болон хуучин гүүрийг сэргээн засварлах төсөл	Нийслэлийн ЗД-ын 2020 оны А/1126 дугаар захирамж
7	Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл	Нийслэлийн ЗД-ын 2020 оны А/1126 дугаар захирамж
8	Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл	Нийслэлийн ЗД-ын 2020 оны А/1126 дугаар захирамж
9	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл	Төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна.
10	Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл	Төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна.
11	Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл	Төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна.



Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл” нь амжилттай хэрэгжсэн учир төслийг үргэлжлүүлэн, санхүүжилтийг нэмж баталсан байна. БНХАУ-ын Засгийн газрын шугамаар хэрэгжиж буй 4 ТАХ-ний гүйцэтгэгч нь Хятадын компани бөгөөд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор боловсон хүчний ажиллах хугацаа хойшилсон учир гэрээг 1 жил хүртэлх хугацаагаар сунгасан байна.

Харин дараах ТАХ нь төслийн хэрэгжилтийн явцад гэрээнд заасны дагуу дараах хөрөнгийг хэсэгчлэн ашиглалтад оруулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. ТАХ-ний хэрэгжилтийн явцад бий болсон хөрөнгийн жагсаалт /сая.төг/

№	ТАХ-ын нэр	Хөрөнгийн жагсаалт				Хөрөнгийн нийт үнэлгээ
		Барилга, дэд бүтэц, зам гүүр	Үнэлгээ	Тоног төхөөрөмж, технологи	Үнэлгээ	
1	Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл	10	2,771.60	5 ширхэг	702.42	3,474.02
2	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр	11	52,840.0			52,840.00
3	Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл			370 ширхэг	3,814.96	3,814.96
4	Замын цагдаагийн газрын ойролцоох уулзварт гүүрэн гарц байгуулах төсөл		90,179.03			90,179.03
5	Яармагийн шинэ гүүр барих болон хуучин гүүрийг сэргээн засварлах төсөл	255.4 у/м, 20.5 м/ө	70,884.06			70,884.06
6	Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголгогийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл	321 у/м, 289.4 у/м	51,307.21			51,307.21
7	Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл	20.9 км	72,617.37			72,617.37
Нийт дүн		21	340,599.27	0	4517.38	345,116.65

Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 11 ТАХ нь бүрэн дуусаагүй учир Барилгын тухай хуулийн 14.1⁸, 14.6⁹, 14.7¹⁰, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 26.6¹¹-д тус тус зааснаар зээлийн хөрөнгийг бүртгэх хугацаа болоогүй байна.

A.2.2 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл тус бүрд ТУХ, ТХН байгуулаагүй, бүтэц орон тоо харилцан адилгүй, батлах эрх бүхий

⁸ 14.3. “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна”

⁹ 14.6 “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтэц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна”

¹⁰ 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль бүрүүтэй этгээд арилгаж, хохирлыг барагдуулна”


¹¹ 26.6 “ТХН нь төслийн эцсийн тайланг журмын энэхүү 12 дугаар Хавсралтын дагуу боловсруулж, санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, Удирдлагын мэдээллийн системд оруулах бөгөөд төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгүүлнэ”



субъект тодорхой бус байгаа нь төслийн нэгжийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3¹², Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10.1.6¹³-д ТУХ болон ТХН-ийг байгуулахаар заажээ.

11 ТАХ-нээс 7 ТАХ буюу 63% нь ТУХ албан ёсоор байгуулаагүй. Шалтгаан нөхцөлийг тодруулбал ТХН-тэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ТАХ-ний хувьд ТУХ-г Нийслэлийн ЗД-ын захирамжаар томилж, салбарын байгууллагаар дамжин хэрэгжиж буй төслүүдэд ТУХ-г байгуулаагүй байна. Графикаар харуулбал:



Мөн Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих буй 11 ТАХ-нээс ТХН байгуулагдсан 6, салбарын байгууллагаар дамжин хэрэгжиж буй 5 ТАХ байна.

Нийслэлд хэрэгжиж буй ТАХ-ний ТХН-ийг Сангийн сайдын болон Нийслэлийн ЗД-ын тушаал, шийдвэрээр байгуулжээ. Үүнд

- “Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл”, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”, “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”-ийн ТХН-ийг Сангийн сайдын тушаалаар,
- “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”, “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл”-ийн ТХН-ийг Нийслэлийн ЗД-ын шийдвэрээр байгуулжээ.

“Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл”-ийн ТХН-ийг Нийслэлийн ЗД-ын шийдвэрээр байгуулсан хэдий ч тухайн төсөл нь машин, тоног төхөөрөмж, технологи нийлүүлэх

¹² 11.1.3 “Төсвийн зарлагын норм, норматив болон төсвийн байгууллагын бүтцийн болон орон тооны жишиг, хязгаарыг тогтоох”

¹³ 10.1.6 “Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ТЭЗ-ийн шийдвэрээр ТУХ-г байгуулах”



гэрээ хийгдсэн бөгөөд гэрээний дагуу тоног төхөөрөмжийг нийлүүлж УСУГ-т хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан тул ТХН ажиллах шаардлагагүй байна.

“Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл”-ийн үйл ажиллагаа нь эхлээгүй учир ТХН-ийг байгуулаагүй байна.

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр авто замын салбарт хэрэгжиж буй 4 ТАХ-ний төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь НАЗХГ бөгөөд төслийн хүрээнд баригдаж байгаа зам гүүрийн барилга байгууламжид зөвхөн захиалагчийн хяналтыг хийсэн нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 14.1¹⁴ -д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй, шаардлагатай баримт материалыг архивлаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1¹⁵-д зааснаар ТХН нь төсвийн байгууллага байна гэж заасан ч ТХН-ийг байгуулах эрх бүхий албан тушаалтан тодорхойгүйгээс Сангийн сайд болон Нийслэлийн ЗД-ийн шийдвэрээр байгуулагдсан байна. Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 6 дугаар хавсралтаар жишиг цалин, орон тоог баталсан ч орон тооны дээд хязгаарыг заагаагүйгээс ТХН-ийн бүтэц орон тоо харилцан адилгүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. ТАХ-ний төслийн хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц орон тоо

№	Төслийн нэр	ТХН-ийг байгуулсан шийдвэр огноо	Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан жишиг									
			Төслийн зохицуулагч	Төслийн менежер /Дэд зохицуулагч/	Санхүүгийн ажилтан	Худалдан авах ажиллагааны ажилтан	ХШҮ-ний Нарийн мэргэжлийн	Орчуулагч	Бусад	Жолооч	Нийт ажилчдын тоо	
1	Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл	Сангийн сайдын 2020 оны №122	1	1	1	1	1	2	1	1	2	11
2	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр	Сангийн сайдын 2019 оны №72	1	1	2	1	1	13	1	4	3	27
3	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	Сангийн сайдын 2019 оны №103	1		2	1	1	7		1		13

¹⁴ 14.1 “ТХН нь дараах чиг үүрэгтэй”

¹⁵ 17.1 “Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол улсын олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна”



4	Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл	Нийслэлийн ЗД-ын 2015 оны А/760	ТХН байгуулах шийдвэр гарсан боловч төслийн онцлогоос шалтгаалан ТХН ажиллах шаардлагагүй байсан тул ажиллаагүй	0															
5	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл	Нийслэлийн ЗД-ын 2019 А/391	1	1					3										5
6	Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл	Нийслэлийн ЗД-ын 2020 А/1080	1	1	1				1	2	1	1	1	1					9

Хүснэгтээс харахад Сангийн сайдын 2019 оны №72 тушаалаар “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь 27 орон тоотой, Нийслэлийн ЗД-ын 2019 А/391 захирамжаар “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл”-ийн ТХН-ийг 5 орон тоотойгоор тус тус баталснаас харахад бүтэц орон тоо эрс ялгаатай байгаа нь харагдаж байна.

Нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Төсөл хөтөлбөрийн хяналт зохицуулалтын хэлтэс нь Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 24.1¹⁶-д зааснаар хяналт тавихаар байна. Эдгээр хэлтсийн зорилго чиг үүрэг давхардсанаас ТАХ-нд тавих хяналт суларсан, ТАХ-тэй холбоотой шаардлагатай баримт бичгийг хадгалж архивлаагүй, ТАХ-нд хяналт тавих ХШҮ-ний мэргэжилтэн томилж батлаагүй, ажиллах боловсон хүчин дутмаг байна.

ТХН-ийг төслийн онцлогт тохируулан байгуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, бүтэц орон тоог тодорхой нэг жишигт оруулах, томилох эрх бүхий албан тушаалтныг тодорхой зааж журамлах нь зүйтэй байна.

А.2.3 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан ТАХ-ний тайланг бэлтгэж үр нөлөөг тооцоогүй байна.

Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 26.1-д зааснаар төслийг дуусгавар болсонд тооцож, 26.2¹⁷, 26.3¹⁸-д зааснаар хэрэгжсэн ТАХ-ний хаалтын тайланг бэлтгэж, үр нөлөөг тооцохоор байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих 11 ТАХ-ээс “Улаанбаатар цэвэр агаар төсөл”-ийн эхний шат бүрэн хэрэгжиж дуусжээ.

Улаанбаатар цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл

¹⁶ 24.1 “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь энэхүү журмын 24.1-д заасан тайланг “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 17, 18 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллагад хүргүүлнэ”

¹⁷ 26.2 “Төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссанаас хойш энэхүү журмын 8 дугаар Хавсралтын дагуу тогтоосон хуваарийн дагуу төсөл, арга хэмжээний үр нөлөөг хөндлөнгийн бие даасан мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. Гэрээ, хэлэлцээрт тусгаагүй тохиолдолд үр нөлөөний үнэлгээ хийлгэх зардлыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ТЭЗ-ийн баацад тусгана”

¹⁸ 26.3 “Үр нөлөөний үнэлгээ ажлыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулах бөгөөд үнэлгээний тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулна”



2019-2020 он Зэвсэгт хүчний 303-р халаалтын зуухыг төвлөрсөн дулааны системд холбох ажил



Байшин сууцны дулаалгын технологийн шийдэл нь



Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 26.1.3-т “гэрээ, хэлэлцээрт тусгасан ажил, арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаанаас өмнө бүрэн хэрэгжсэн, эсхүл цаашид үргэлжлүүлэх шаардлагагүйг холбогдох талууд харилцан тохиролцсон” тохиолдолд ТАХ–г дууссанд тооцох бөгөөд “Улаанбаатар Цэвэр агаар төсөл”-ийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай” тогтоолоор “Цэвэр агаар” нэмэлт санхүүжилтийн төслийг баталснаар үргэлжлэн хэрэгжиж үр нөлөөний үнэлгээ хийгдэхээргүй байна.

А.2.4 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний үндсэн болон хүүгийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2¹⁹, 32 дугаар зүйлийн 32.1²⁰-д заасны дагуу Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг төлж барагдуулахаар заажээ.

Нийслэлд хэрэгжиж буй 3 ТАХ-ний 9 дамжуулан зээлдүүлэх гэрээний 2018-2020 онд төлөгдөх зээлийн үндсэн төлбөр 10.46 сая USD, 1.11 сая EUR, хүүгийн төлбөр 5.14 сая USD, 2.91 сая EUR байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөгдөх үндсэн болон хүүгийн дүн /сая.валют/

№	Гэрээний дугаар	Төслийн нэр	2020 оны 12-р сарын байдлаар	Валют
---	-----------------	-------------	------------------------------	-------

¹⁹ 31.3.2 “Дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх”

²⁰ 32.1 “Дэд болон эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах үүрэгтэй”



		Зээлийн гэрээний дүн	Үндсэн зээлийн төлбөр	Хүүгийн төлбөр	
1	3098-MON	27.50	6.60	2.23	USD
2	3099-MON	22.50	3.86	2.51	USD
3	83097-EIB	21.00	1.11	2.51	EUR
4	3525-MON	37.11	Хугацаа болоогүй		USD
5	3526-MON	29.24	Хугацаа болоогүй		USD
6	FI N'83.873	29.00	Хугацаа болоогүй		EUR
7	46581	9.70	Хугацаа болоогүй		USD
8	3694-MON	60.00	Хугацаа болоогүй		USD
9	3695-MON	20.00	Хугацаа болоогүй		USD
Нийт USD		176.81	10.46	5.14	
Нийт EUR		50.00	1.11	2.91	

Эх сурвалж: Нийслэлийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэс

Дээрх хүснэгтээс харвал Нийслэл болон Сангийн яам хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээтэй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”, “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл”, “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”-ийн 6 дамжуулан зээлдүүлэх гэрээний үндсэн төлбөр, 4 гэрээний хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийн хугацаа болоогүй байна.

Харин “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн 3098-MON, 3099-MON, 83097-EIB гэрээний үндсэн төлбөр 10.46 сая.USD, 1.11 сая.UER, 3098-MON, 3099-MON, 83097-EIB, 3526-MON, FI N'83.873 гэрээний хүүгийн төлбөр 5.14 сая.USD, 2.91 сая.EUR -ийн хүүгийн төлбөр тус тус төлөгдөхөөс 2020 оны жилийн эцсийн байдлаар төлөлт хийгдээгүй байна.

Шалтгаан нөхцөлийг тодруулбал:

- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж TAX-ний зээлийн эргэн төлөлтийн санхүүжилт нь Сангийн сайдын төсвийн багцад хамаардаг гэтэл дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Нийслэлийн ЗД төлөхөөр туссан учир Сангийн яам, Нийслэлийн хооронд ойлголтын зөрүү үүссэн
- Нийслэлд төвлөрүүлж байгаа орлогыг Сангийн яам бүрэн хэмжээгээр татсанаас зээлийн эргэн төлөлтийг төлөх эх үүсвэргүй болсон
- Дамжуулан зээлдүүлэх гэрээний үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийн төлбөрийг Нийслэлийн тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгадаггүй

Дээрх дамжуулан зээлдүүлэх гэрээ тус бүрд хоногт тутам 0.5% алданги тооцохоор гэрээнд тусгасан ч зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр төлөх



хугацаа хэтэрсэн ТАХ-нд 2020 оны 12 сарын байдлаар Сангийн яамтай тооцоо нийлж алдангийг тооцоогүй байна.

Нийслэлд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ТАХ-ний зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт тавих хяналт сул Сангийн яамтай тооцоо нийлээгүй байгаа нь Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2²¹, 32 дугаар зүйлийн 32.1²², 32.2²³-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй, зээлийн эргэн төлөлтийг хийгээгүй байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний үндсэн болон хүүгийн төлбөр төлөх хугацаанд хяналт тавьж гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлж барагдуулах, эрсдэл үүссэн тохиолдолд холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлж ажиллах нь зүйтэй байна.

А.3 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-нд төсөл хэрэгжүүлэгч байгууллага ХШҮ хийх ажлын хэсгийг томилж төслийн явцад хяналт тавих үүрэгтэй боловч ажлын хэсэг томилоогүй, төслийн явцад хяналт хэрэгжүүлээгүй байна.

А.3.1 Хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ нь Шилэн дансны тухай хуульд заасан зарчмыг баримтлаагүй, шилэн дансны мэдээлэл бүрэн хөтлөөгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6²⁴-д заасны дагуу Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээний мэдээллийг шилэн дансны мэдээлэл хөтлөхөөр тусгажээ.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 11 ТАХ-ээс шилэн дансны мэдээлэл хөтөлсөн 8 ТАХ, хөтөлж эхлээгүй болон хөтлөөгүй 3 ТАХ байна.
/Хавсралт 1/

Засгийн газрын гадаад зээлээр хөрөнгөөр хэрэгжиж буй “Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл”-ийн үндсэн үйл ажиллагаа 2020 оны байдлаар эхлээгүй учир шилэн данс хөтлөгдөөгүй байна.

Мөн Австрийн Засгийн газрын санхүүжилттэй “Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл”-ийн

²¹ 31.3.2 “дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх”

²² 32.1 “Дэд болон эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах үүрэгтэй”

²³ 32.2 “Тухайн салбарт төрөөс баримталж байгаа бодлого, зохицуулалтаас шалтгаалж дамжуулан зээлдүүлсэн зээл төлөгдөхгүй байх эрсдэл үүссэн тохиолдолд тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ тухай мэдэгдлийг нотлох баримт, тооцоо, судалгааны хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал, дүгнэлт гаргуулахаар нэн даруй хүргүүлнэ”

²⁴ 3.2.6 “Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж”



хүрээнд УСУГ-т тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи нийлүүлж, чадавхижуулах сургалт хийгдсэн тул шилэн данс хөтлөөгүй байна.

2018-2020 онд “Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл”, “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл”, “Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл” зэрэг төслүүд нь шилэн дансанд мэдээллийг дутуу болон огт оруулаагүй, хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалт, орлого, зарлагын мэдээллээ хөтлөөгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6²⁵, 3.4²⁶-т заасныг хэрэгжүүлээгүй байна. /Хавсралт 2/

Хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй нийт төсөл хөтөлбөрүүд Шилэн дансны мэдээллийг хөтлөхдөө 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авсан бараа ажил үйлчилгээ хэсэгт мэдээлэл оруулахдаа худалдан авалтыг санхүүжилтийн өссөн дүнгээр мэдээлээгүй, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл, худалдан авалтын төлөвлөгөө тайлан зэрэг мэдээллүүдийг мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуульд заасан зарчмыг баримтлаагүй, шилэн дансны мэдээлэл бүрэн хөтлөөгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6²⁷, 3.4²⁸-т заасныг хэрэгжүүлээгүй байна.

А.3.2 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-нд Нийслэлийн ЗДТГ-аас төслийн үйл ажиллагаанд 2018-2020 онд ХШҮ-г хийгээгүй байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс төслийн үйл ажиллагаанд ХШҮ хийхгүй байгаа нь ТАХ хугацаандаа чанартай хэрэгжиж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 18 дугаар зүйлд зааснаар Нийслэлийн ЗД төслийн хэрэгжилтийг төлөвлөх үе шатанд ХШҮ-ний ажлын хэсгийг байгуулахаар заасан ч Нийслэлд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-нд хяналт тавих ХШҮ-ний ажлын хэсгийг байгуулаагүй байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”, “Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл”-ийн үндсэн үйл ажиллагаа эхлээгүй учир ХШҮ хийгдээгүй байна.

²⁵ 3.2.6 “Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж”

²⁶ 3.4 “Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно”

²⁷ 3.2.6 “Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж”

²⁸ 3.4 “Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно”



“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”, “Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл”, “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл”-үүд нь ТХН-тэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд ХШҮ-ний ажилтныг ТХН-ийн бүтэц орон тоонд тусгаж дотооддоо ХШҮ хийж байгаа нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 24.1 дэх заалтыг хэрэгжүүлжээ.

Мөн БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Замын цагдаагийн газрын ойролцоох уулзварт гүүрэн гарц байгуулах төсөл”, “Яармагийн шинэ гүүр барих болон хуучин гүүрийг сэргээн засварлах төсөл”, “Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл”, “Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл”-үүдийг БНХАУ-ын Төмөр замын 20-р товчоо групп компани гүйцэтгэж байгаа бөгөөд үе шатны хяналтыг НАЗХГ-аас хэрэгжүүлэн ажилладаг байна.




БҮЛЭГ Б. ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАХ-НИЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХОД ОНОВЧТОЙ БОДЛОГО, НЭГДСЭН УДИРДЛАГА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ДУТМАГ, ҮЕ ШАТТАЙГААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТАХ-Г ТАЙЛАГНАХ, ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ, ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ АСУУДАЛ ТОДОРХОЙГҮЙ, ГҮЙЦЭТГЭЛ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ДОТООДЫН ХЯНАЛТ СУЛ БАЙНА.

Нийслэлийн хэмжээнд 2018-2020 оны байдлаар Монгол улсын Засгийн газрын түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран буцалтгүй тусламж, техник тусалцаагаар 67.7 сая USD, 4.8 сая EUR, 3.6 сая CHF 9 ТАХ хэрэгжсэнээс 5.1 сая USD 2 ТАХ бүрэн хэрэгжиж, 62.6 сая USD, 4.8 сая EUR, 3.6 сая CHF 7 ТАХ хуваарийн дагуу дамжиж хэрэгжиж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжаар хэрэгжиж буй төслийн жагсаалт

№	Санхүүжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Төслийн нийт санхүүжилт /сая..валют/	Эхэлсэн огноо	Дуусах огноо
1	АХБ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	3,7 USD	2014	2019
2	АХБ	Гэр хорооллын нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл	2.0 USD	2020	2023
3	АХБ	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бийх хотын шинэчлэл салбарын төсөл	53.0 USD	2019	2027
4	АХБ	Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл	3.0 USD	2020	2023
5	КОЙКА ОУБ	Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв, инкубатор төсөл-2	1.4 USD	2016	2020
6	ШХА	Хотын Засаглалыг Сайжруулах Төсөл	4.8 CHF	2015	2022
7	НҮБ-ийн ХХ	Улаанбаатар хотод тогтвортой хөгжлийн зорилгуудыг нутагшуулах санаачилга	0.4 USD	2017	2021
8	ХБНГУ-ын ХЭДХАХЯам, ШХА	Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл	3.6 EUR	2018	2021
9	ЖАЙКА ОУБ	Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл - 3	4.2 USD	2018	2023

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-г хэрэгжиж буй салбараар нь авч үзвэл байгаль орчин, нийгэм, барилга хот байгуулалтын салбаруудад хэрэгжиж байна. Үүнийг графикаар харуулбал: **Төсөл хэрэгжиж буй салбар** /График 3/



Б.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-нд тавигдах үндсэн шаардлагыг төслийн онцлогт тохируулан боловсруулаагүй, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.



Б.1.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-ний зорилго, зорилт нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялджээ.

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд тавигдах ерөнхий шаардлагыг Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 4.1 дэх заалтад тусгажээ.

Журмаар Нийслэлийн ЗДТГ нь тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлтийн шатанд ТАХ-г хууль, тогтоомж бодлогын баримт бичигт нийцүүлж саналыг холбогдох байгууллагад уламжлах чиг үүрэгтэй байна. /Хавсралт 3/

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний зорилго, зорилт нь Монгол улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тусч, Засгийн газрын дунд болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогуудад бүрэн уялдаагүй нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 4.1.2²⁹-д заасан шаардлагад нийцээгүй байна.

Энэ нь төсөл хэрэгжүүлэгч байгууллага төслийн өмнөх үе шатны ажлыг хэрэгжүүлээгүй, бодлогын баримт бичигтэй бүрэн уялдуулаагүй, суурь судалгааны баримт бичгийг боловсруулаагүй, төслийн хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлоогүйгээс болсон байна.

Мөн Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлд “Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг шийдвэрлэх үйл явц”-ыг заажээ.

Нийслэлд тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ээс 3 ТАХ Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцүүлэн суурь судалгаа хийж хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, урьдчилан шаардлагатай баримт бичгийг боловсруулан ТАХ-г батлуулжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт9. Шаардлагатай баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлсэн ТАХ

№	Санхүүжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Дараах үнэлгээг тооцсон эсэх					
			Техник, эдийн засгийн		Нийгмийн		Байгаль орчинд нөлөөлөх байдлын	
			Тийм, үгүй	Огноо	Тийм, үгүй	Огноо	Тийм, үгүй	Огноо
1	ХБНГУ-ын Холбооны ЭЗХАХЯ, (BMZ), ШХА (SDC)	Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл үе шат II	тийм	2018	тийм	2018	тийм	2018

²⁹ 4.1.2 “Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан байх”



2	Уур амьсгалын ногоон сан, Өндөр технологийн сан	Улаанбаатар хотын орлогд нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	Урьдчилсан ТЭЗҮ болон нарийвчилсан ТЭЗҮ хийгдсэн	2017 2020			үгүй
3	АХБ	Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл	Тийм.	2017	Тийм	2017	Тийм. 2017

Харин ТАХ батлагдахаас өмнө суурь судалгааны баримт бичиг ТЭЗҮ, нийгмийн болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулаагүй дараах ТАХ байна.

- АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын орлогд нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл” нь нарийвчилсан ТЭЗҮ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгээгүй байна.
- Жайка олон улсын байгууллагын шугамаар хэрэгжиж байгаа “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл-3” нь суурь судалгааны баримт бичгийг боловсруулаагүй
- АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Гэр хорооллын нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл” нь техник эдийн засгийн үнэлгээ, зураг төсөв, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй.

Дээрх төслүүд нь дараах шалтгаанаар суурь судалгааны баримт бичгийг боловсруулаагүй байна. Үүнд:

1. Төсөл батлагдахаас өмнө суурь судалгааны баримт бичиг боловсруулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй
2. Зарим тохиолдолд төслийн өмнөх шатанд хийгдсэн суурь судалгааны баримт бичиг санхүүжүүлэгч байгууллагын шаардлагыг хангадаггүй
3. Тухайн салбарын боловсон хүчнийг чадавхжуулах, шинэ технологи нэвтрүүлэх, бодлогын баримт бичиг боловсруулах чиглэлээр хэрэгждэг төслүүдэд суурь судалгааны баримт бичиг боловсруулах шаардлагагүй зэрэг шалтгааны улмаас хийгдээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 4.3-т заасан “Төслийн онцлогийг харгалзан техник, эдийн засгийн үзүүлэлт, нийгэм болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тооцсон байна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Журамд ТАХ-ний төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг Нийслэлийн ЗДТГ хариуцан тухайн ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж суурь судалгааны баримт бичгийг боловсруулан төслийн саналын хамт төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заасан хэдий ч Нийслэлийн ЗДТГ-т гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-г нэгдсэн бодлого, удирдлагаар хангах зорилготой “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс”, “Төсөл, хөтөлбөрийн хяналт



зохицуулалтын хэлтэс"-үүдийн зорилго чиг үүрэг давхардсанаас ТАХ-ний зарим үе шатны ажлууд орхигдож, хяналт суларсан байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу дээрх ТАХ нь суурь судалгааны баримт бичгийг боловсруулаагүй байна. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ санхүүжүүлэгч байгууллагаас шалтгаалаад шууд санхүүжиж байгаа учир төсөл батлагдахын өмнөх үе шатны ажил хийгдээгүй байна.

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний үндсэн шаардлагыг төсөл тус бүрийн онцлогт нийцүүлэн журамд зохицуулалт хийх нь зүйтэй.

Б.1.2 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлсэн төслийн саналыг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

Нийслэлийн ЗДТГ нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 5.1³⁰-д заасны дагуу ТАХ-г хууль тогтоомж, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, төслийн техник, эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн хэрэгжүүлэх төслийн саналыг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ гэж заажээ.

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний зорилго, зорилт нь Монгол улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тусч, Засгийн газрын дунд болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогуудад зарим ТАХ уялдаагүй, ТАХ батлагдахаас өмнө суурь судалгааны баримт бичиг ТЭЗҮ, нийгмийн болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зарим ТАХ-ний хүрээнд боловсруулагдаагүй зэрэг зөрчлүүд байгааг дээр дурдсан.

Мөн төсөл батлагдахаас өмнө дээрх шаардлагуудыг хангуулан ТАХ-г хэрэгжүүлэх саналыг Нийслэлийн ЗДТГ гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн эсэхийг судалгааны хүснэгт болон ярилцлага хийх байдлаар тодруулахад тусламжийн төслүүдэд санал хүргүүлсэн эсэх тодорхойгүй, санал хүргүүлсэн албан бичгийг нотлох баримтын хүрээнд шаардахад Нийслэлийн ЗДТГ болон холбогдох байгууллагууд, ТХН-ээс ирүүлээгүй.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын

³⁰ 5.1 “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, төслийн техник, эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн хэрэгжүүлэх төслийн саналыг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн баримт бичгийн загвар” маягтад зааснаар боловсруулах бөгөөд салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”



тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 5.1³¹-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шалтгаан нөхцөлийг тодруулахад архивын материалд байхгүй, өмнөх ажил хариуцаж буй албан тушаалтнууд хүлээлгэн өгөөгүй гэсэн тайлбарыг хийсэн нь тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж ТАХ-ний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлд нэгдсэн удирдлага дутмаг байгааг харуулж байна.

Б.2 Үе шаттайгаар хэрэгжиж буй ТАХ-г тайлагнах, төслийн үр өгөөж, үр нөлөөг тооцох асуудал тодорхойгүй байна.

Б.2.1 Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна.

Нийслэлд тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 6 ТАХ-ээс АХБ-ны тусламжаар хэрэгжиж буй “Гэр хорооллын нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл”, “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”, “Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл”-ийн үндсэн үйл ажиллагаа эхлээгүй байна.

Мөн “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл – 3”, “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл үе шат II”-үүд тухай салбарын мэргэжилтнийг сургах, бодлогын баримт бичиг боловсруулах, технологи нэвтрүүлэх зорилготой хэрэгжиж байна.

Нийслэлд хэрэгжиж буй 6 ТАХ-ээс “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих 0380-МОН-той төсөл” нь бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд 8,945.97 сая төгрөгийн хөрөнгийг УСУГ-т хүлээлгэн өгчээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10. Буцалтгүй тусламжаар нийлүүлсэн хөрөнгийн жагсаалт

№	Нийлүүлэгдсэн хөрөнгийн жагсаалт	Тоо хэмжээ	Ашиглах байгууллага	Бүртгэж хүлээн авах байгууллага
1	Үйлдвэрийн насос станц	4,16 ширхэг	УСУГ	НӨАУГ
2	Махын насос станц	Шилэн кабель	УСУГ	НӨАУГ
3	Төвийн насос станц	Давтамж хувиргагч	УСУГ	НӨАУГ
4	УСУГ-ын төв дээрх удирдлагын төв, /нэгдсэн удирдлагын төв/		УСУГ	НӨАУГ
5	Шинээр барих түгээх сүлжээний удирдлагын хяналтын худаг	20 ширхэг	УСУГ	НӨАУГ
6	Шинээр барих хэмжих худаг	10 ш	УСУГ	НӨАУГ
7	Шинэчлэх одоо байгаа цэгт шинэчлэлт	10	УСУГ	НӨАУГ
8	Гачуурт насос станц /шилэн кабель, склада/	Шилэн кабель склада	УСУГ	НӨАУГ
9	Усны алдагдлыг илрүүлэх систем	Хотын ус хангамжийн шугам сүлжээнд	УСУГ	НӨАУГ

³¹ 5.1 “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, төслийн техник, эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн хэрэгжүүлэх төслийн саналыг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн баримт бичгийн загвар” маягтад зааснаар боловсруулах бөгөөд салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”



10	Төв цэвэрлэх байгууламжид диффузер нийлүүлэх	10000	УСУГ	НӨАУГ
----	--	-------	------	-------

УСУГ нь дээрх төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг бүрэн ашиглаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар УСУГ-т дээр диспетчерийн нэгдсэн хяналт удирдлагын төвийг шинээр байгуулж, өмнөх системүүдийг нэгтгэсэн байна. Уг нэгдсэн хяналт удирдлагын төв байгуулагдсанаар УСУГ -ын эх үүсвэрүүд болох дээд эх үүсвэр, төв, Гачуурт, үйлдвэр, мах, Нисэхийн станцууд, дахин дамжуулах өргөлтийн насос станцууд, усан сангууд болон түгээх шугамын зохицуулах хаалттай хяналтын цэгүүдийг бүгдийг алсаас хянаж удирдах боломжтой болжээ. Ингэснээр Улаанбаатар хотын ус хангамжийн системд горимын оновчлол хийх, системийг илүү үр ашигтай удирдах техникийн боломж бүрджээ.

Тухайн төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг Нийслэлийн өмчид бүртгүүлэхээр 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 304 дугаартай албан бичгээр НӨАУГ-т хандсан боловч өнөөдрийн байдлаар хөрөнгийг бүртгэж аваагүй байна.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих 0380-МОН-той төсөл” нь үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд ТАХ бүхэлдээ хэрэгжиж дуусаагүй учир Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 25.1.3³²-д заасан нөхцөл байдал үүсээгүй учир хөрөнгийг Нийслэлийн өмчид бүртгэх хугацаа болоогүй байна.

Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ бүрэн дуусаагүй учир Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 25.6-д зааснаар хөрөнгө бүртгэх хугацаа болоогүй байна.

Б.2.2 Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан ТАХ-ний тайланг бэлтгэж үр нөлөөг тооцоогүй байна.


Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 24.3, 24.5, 25.1.1-25.1.3-д зааснаар төслийг дуусгавар болсонд тооцож тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлж, 25.3-25.7-д зааснаар хэрэгжсэн ТАХ-ний хаалтын тайланг бэлтгэж, үр нөлөөг тооцохоор байна.

Аудитад хамрагдсан буцалтгүй тусламжийн 6 ТАХ-ээс “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих 0380-МОН-той төсөл” бүрэн хэрэгжиж дууссан байна.

³² 25.1.3 “гэрээ, хэлэлцээрт тусгасан ажил, арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаанаас өмнө бүрэн хэрэгжсэн, эсхүл цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй болсон талаар холбогдох талууд харилцан тохиролцсон”



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих 0380-МОН-той төсөл



Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 25.2³³, 25.4³⁴-д зааснаар Нийслэлийн ЗДТГ бүрэн хэрэгжиж дууссан ТАХ-нд хөндлөнгийн үр нөлөөний үнэлгээ хийхээр заасан ч хийгдээгүй байна.

Шалтгаан нөхцөлийг тодруулахад:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6³⁵, 14.7³⁶-д заасны дагуу барилга байгууламж, ашиглалтад оруулах, зүгшрүүлэх хугацаа болоогүй тул үнэлгээ хийгдэхгүй
- Тухайн төсөл нь үе шаттай хэрэгжиж байгаа бөгөөд төсөл бүрэн хэрэгжиж дууссаны дараа нийт төслийн хэрэгжилтэд төслийн үр өгөөж, үр нөлөөний үнэлгээ хийгдэнэ гэсэн нь журмын заалттай нийцээгүй бөгөөд журамд үе шаттай хэрэгжиж ТАХ-ний үр нөлөөг хэрхэн тооцох тухай нарийвчлан тусгаагүй, тодорхойгүй байна.

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-аар ТАХ бүрэн дуусгавар болоход үр нөлөөг тооцохоор заасан бөгөөд үе шаттай хэрэгжиж буй

³³ 25.2 “Төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссанаас хойш гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний загвар” маягтын дагуу тогтоосон хуваарийн дагуу төсөл, арга хэмжээний үр нөлөөг хөндлөнгийн бие даасан мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. Гэрээ, хэлэлцээрт тусгаагүй тохиолдолд үр нөлөөний үнэлгээ хийлгэх зардлыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ТЭЗ-ийн багцад тусгана”

³⁴ 25.3 “Үр нөлөөний үнэлгээ хийлгэх ажлыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулах бөгөөд үнэлгээний тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулна”

³⁵ 14.6 “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтэц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна”

³⁶ 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна”



ТАХ-ний үе шатны ажил бүрэн дуусгавар болоход төслийн үр өгөөжийг хэрхэн тооцохыг журамд зохицуулаагүй байна.

Б.3 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн явцад 2018-2020 онд төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс хяналт тавиагүй, ажлын хэсэг томилоогүй, мэргэжилтэн боловсон хүчин дутмаг, дотоодын хяналт сул байна.

Б.3.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ нь Шилэн дансны тухай хуульд заасан зарчмыг баримтлаагүй, шилэн дансны мэдээллийг бүрэн хөтлөөгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6³⁷-д заасны дагуу Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй ТАХ-ний төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээний мэдээллийг шилэн дансанд хөтлөхөөр тусгажээ.

Хүснэгт 11. Шилэн дансны мэдээлэл

№	Төслийн нэр	Хамрагдах огноо	Нийт мэдээлэх	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлэ эгүй	Мэдээлсэн хувь	Хугацаа хоцроосон хувь
1	1.1 Улаанбаатар гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл, хөтөлбөр	2018	185	170	11	4	91.90%	5.90%
		2019	367	346	17	4	94.30%	4.60%
		2020	306	288	14	4	94.10%	4.60%
		Нийт	764	710	42	12	92.90%	5.90%
2	1.2 Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	2020	156	25	131	13	16.03	83.97
		Нийт	156	25	131	13	16.03	83.97
3	Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл	2020	28	25	2	1	89.3	7.1
		Нийт	156	25	131	13	16.03	83.97
4	Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл	Үндсэн үйл ажиллагаа эхлээгүй учир шилэн дансны мэдээлэл хөтлөхгүй.						
5	Гэр хорооллын нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл	Үндсэн үйл ажиллагаа эхлээгүй учир шилэн дансны мэдээлэл хөтлөхгүй.						
6	Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл	Шилэн данстай холбоотой мэдээлэл ирүүлээгүй.						

Тусламжийн зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй нийт төсөл хөтөлбөрүүд Шилэн дансны мэдээллийг хөтлөхдөө 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авсан бараа ажил үйлчилгээ хэсэгт мэдээлэл оруулахдаа худалдан авалтыг санхүүжилтийн өссөн дүнгээр мэдээлээгүй, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл, худалдан

³⁷3.2.6 “Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж”



авалтын төлөвлөгөө тайлан зэрэг мэдээллүүдийг мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуульд заасан зарчмыг баримтлаагүй, шилэн дансны мэдээлэл бүрэн хөтлөөгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6³⁸, 3.4³⁹-т заасныг хэрэгжүүлээгүй байна.

Б.3.2 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний явцад дотоод болон хөндлөнгийн аудит, ХШҮ хийгээгүй байна.

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 17 дугаар зүйлд зааснаар Нийслэлийн ЗДТГ төслийн хэрэгжилтийг төлөвлөх үе шатанд ХШҮ-ний ажлын хэсгийг байгуулахаар заасан ч тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавих ХШҮ-ний ажлын хэсгийг байгуулаагүй байна.

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Гэр хорооллын нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл”, “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”, “Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл”-үүд нь ТХН-тэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд ХШҮ-ний ажилтныг ТХН-ийн бүтэц орон тоонд тусган батлуулсан байх бөгөөд төсөл эхлэлийн үе шатандаа байгаа учир ХШҮ хийгдэх хугацаа болоогүй байна.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”, “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл”, “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл-3” төслүүдийн хувьд төслийн үйл ажиллагааг 2014-2019 онуудад эхэлсэн хэдий ч Нийслэлийн ЗДТГ-аас төслийн явцад ХШҮ, дотоод болон хөндлөнгийн аудит хийгээгүй нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 23.2⁴⁰ дахь заалтыг хэрэгжүүлээгүй, ХШҮ хийгээгүй байна.

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-д АХБ-ны хяналтын багаас төслийн үр дүн, явцын талаарх хяналтыг Сангийн яам, Нийслэлийн ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч байгууллага, хамтран ажиллагч төрийн байгууллагуудтай хамтран 2018, 2019 онуудад төслийн явцад хяналтыг хэрэгжүүлсэн байна. Мөн тусламжийн төслүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд санхүүжүүлэгч байгууллага олон улсын аудитын компаниар аудит хийлгэж хянадаг байна.

³⁸ 3.2.6 “Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж”

³⁹ 3.4 “Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно”

⁴⁰ 23.2 “ХШҮ-ний ажлын хэсэг нь төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүр дараа жилийн эхний улиралд багтаан хийх бөгөөд үнэлгээний тайланг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн үнэлгээний тайлангийн загвар” маягтын дагуу боловсруулна. ТХН нь тайланг ТУХ-нд тухай бүр танилцуулж, холбогдох мэдээлэл, тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулна”



АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ нь бүрэн дуусаагүй, хяналт хэрэгжүүлж үр нөлөөг тооцоогүй учир зээлийг үр дүнтэй ашигласан эсэхийг тодорхойлох боломжгүй байна.
2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход оновчтой бодлого, нэгдсэн удирдлага, хууль эрх зүйн орчин дутмаг, үе шаттайгаар хэрэгжиж буй ТАХ-г тайлагнах, төслийн үр өгөөж, үр нөлөөг тооцох асуудал тодорхойгүй, гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих дотоодын хяналт хэрэгжихгүй байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний Нийслэлд дамжуулан зээлдүүлэх гэрээний зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн дүнг Нийслэлийн жил бүрийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах

Нийслэлийн ЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар

- 2018-2020 онд хамаарах дамжуулан зээлдүүлэх гэрээний үндсэн болон хүүгийн эргэн төлөх хуваарийг дахин тооцоолох, алдангийн дүнг тооцож Сангийн яамтай тулган баталгаажуулах;
- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-г нэгдсэн удирдлагаар хангах, ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд хяналт тавих нэгжийг оновчтой зөв зохион байгуулалтад оруулах, мэргэжлийн боловсон хүчнээр хангах;
- Дамжуулан зээлдүүлэх гэрээнд эрсдэлийн үнэлгээ хийж, зээлийн эргэн төлөлтийн чадварыг тодорхойлж шаардлага хангасан ТАХ-нд дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулж байх;
- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний дамжуулан зээлдүүлэх гэрээний үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх;
- Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах” журмыг ТАХ-ний онцлогт тохируулан өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад саналын хамт уламжлах;
- ТХН-ийн бүтэц орон тоо харилцан адилгүй байгааг журамд заасны дагуу нэг жишигт оруулах, ТХН-ийг төслийн онцлогт тохируулан байгуулах, төсөл хэрэгжих явцад дотоодын хяналтыг тогтмол хэрэгжүүлж хэвших;



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Жагжин Д.Сүхбаатарын талбай 7, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99
http://www.aa.gov.mn

2021.04.23 № 06/1653
Тасгийг _____-ны № _____-т

Санал өгөх тухай

Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн "Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (АГТ-2021/10-ШТА-ГА) тайланд санал хүргүүлэх төслийг хүлээн авч танилцуулав.

Аудитын тайлангийн төсөлд Сангийн яам болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хооронд байгуулсан дамуулан зээлдүүлэх гэрээний 2018-2020 онд төлөгдөх 3098-MON гэрээний 6.6 сая /USD/, 30-99 MON гэрээний 3.8 сая /USD/, 83097-EIB гэрээний 1.1 сая /USD/ үндсэн төлбөр, 3098-MON гэрээний 2.2 сая /USD/, 3098-MON гэрээний 2.5 сая /USD/, 83097-EIB гэрээний 2.5 сая /EUR/, 3526-MON гэрээний 0.4 сая /USD/, FI N83 873 гэрээний 0.4 сая /EUR/ хүүгийн төлбөр, нийт зээлийн үндсэн төлбөр 10.45 сая /USD/, 1.10 сая /EUR/, хүүгийн төлбөр 5.14 сая /USD/, 2.91 сая /EUR/-г графийн дагуу төлсөнгүй. Нийслэлийн төсвийн өрөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгажгүй. Сангийн яамтай тулган баталгаажуулалт хийгдээгүй гэсэн шалтгаанаар модордож албан шаардлага өгөх санал ирүүлсэн байна.

Гадны зээл тусламжийн хөрөнгөөр Нийслэлд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн арга хэмжээг Сангийн яамнаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу нийслэлийн төсвийн өрөнхийлөн захирагчийн жил бүрий санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгажгүй тусгажгүй байгууллагаар баталгаажуулж өрсөн. 2018, 2019 онд нийслэлд хэрэгжиж байгаа дамуулан зээлдүүлэх гэрээний санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний төсөл Сангийн сайдын бэлдэд шилжсэн тул нийслэлийн төсвийн өрөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгажгүй болно.

Сангийн яамнаас өгсөн зөвлөмжийн дагуу эхний ээлжинд 2020 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар дамуулан зээлдүүлэх гэрээний ашиглалтын тооцоог Сангийн яамны Санхүү бодлогын газартай тооцоо нийлж баталгаажуулсны үндсэн дээр Нийслэлийн төсвийн өрөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан.

Дамуулан зээлдүүлэх 3098-MON, 3099-MON, 83097-EIB, 3526-MON, FI N83 873 гэрээний үндсэн болон хүүгийн төлбөрийн арга төлөвлөгөө зээлийн гэрээний графийн дагуу Сангийн яамтай тооцоо нийлэн баталгаажуулалт хийж ахсан үншэд үндсэн болон хүүгийн төлбөрийг графийн дагуу тооцоход хүүгийн төлбөргүлд зөрүүтэй тооцонгүд гэрч байгаа тул тооцоог нарийвчлан баталгаажуулж ажил хийгдэж байна.

Сангийн яам нь Төсвийн тухай хуулийн дагуу жил бүр нийслэлийн, төсвийн орлого, зарлагыг хянаж зарлагаас давсан орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх шийдвэрийг Улсын Их Хурлаар батлуулах ёррогддог. Энэхүү айлцажээ нийслэлийн төсвөөс 2018 онд 208.5 тэрбум төгрөг, 2019 онд 289.1 тэрбум төгрөг, 2020 онд 108.1 тэрбум төгрөг бүгд 605.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

C:\2021\on\alban\bin\CTCX.docx
111020061424

2

Нийслэлийн төсвөөс жилд дунджаар 200 гаруй тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байгаа нь дамуулан зээлийн өр, төлбөрийн төлөх санхүүгийнх үүсвэр дутагдаж зээлийн арга төлөлт хийх боломжгүй нөхцөл байдалыг үүсгэж байгаа талбар өгсөн.

Иймд албан шаардлагыг зөвлөмж болгох саналтай байгааг эргэн хянаж шийдэрлэх өгнө үү.

САНХҮҮ, ТӨРИЙН БАНГИЙН
ХЭЛТСЭЙН ДАРГЫН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Н.НАРАНБААТАР


**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Жагжин Д.Сүхбаатарын талбай 7, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99
http://www.aa.gov.mn

2021.04.30 № 03/1743
Тасгийг _____-ны № _____-т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Нийслэл дэх Төрийн аудитын газраас 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 837 дугаар албан бичгээр ирүүлсэн "Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (АГТ-2021/10-ШТА-ГА) тайлангийн төсөлтэй танилцуулав.

Тайланд тусгайлан өгөх саналгүй болно.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Т.ОЮУНЧИМЭГ

D:\2021 on\A- 5TG.docx
111020061424



САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 03/1743 дугаартай албан бичгээр тайлангийн төсөлтэй танилцан, саналгүй гэж илэрхийлсэн.

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2021 оны 04 дүгээр сарын 23-ны 06/1653 дугаартай албан бичгээр тайлангийн төсөлтэй танилцаж, албан шаардлагын төслийг зөвлөмж болгох санал ирүүлсэн. Шалгагдагч байгууллагын саналыг Монгол улсын Ерөнхийн аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын 5.2-т заасны дагуу дарга, тэргүүлэх аудиторт танилцуулж зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.



ХАВСРАЛТУУД

Хавсралт 1

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байдал

№	Төслийн нэр	2018-2021 ОНЫ ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН МӨРИЙН ДУГААР
1	Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл	Тусгагдаагүй
2	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр	95
3	Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл	99
4	Яармагийн шинэ гүүр барих болон хуучин гүүрийг сэргээн засварлах төсөл	Тусгагдаагүй
5	Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл	97
6	Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл	98
7	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл	101
8	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	100
9	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	102
10	Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл	Тусгагдаагүй
11	Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл	Тусгагдаагүй

Хавсралт 2

Шилэн дансны мэдээлэл

№	Төсөл хөтөлбөр нэр	Төсөл хэрэгжүүлэгч	Эхэлсэн огноо	Дуусах огноо	Шилэн дансны мэдээлэл хөтлөлт
1	Улаанбаатар цэвэр агаар төсөл	Нийслэлийн ЗДТГ	2020-04-10	2021-12-31	Тийм
2	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл	Нийслэлийн ЗДТГ	2014	2021	Тийм
3	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	Нийслэлийн ЗДТГ	2019	2027	Тийм
4	Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологи нэвтрүүлэх төсөл	УСУГ	2017	2024	Үгүй
5	Замын цагдаагийн газрын ойролцоох уулзварт гүүрэн гарц байгуулах төсөл	Нийслэлийн ЗДТГ, НАЗХГ	2016-11-15	2019-09-30	Тийм
6	Яармагийн шинэ гүүр барих болон хуучин гүүрийг сэргээн засварлах төсөл	Нийслэлийн ЗДТГ, НАЗХГ	2016-01-10	30-6-2021	Тийм
7	Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл	Нийслэлийн ЗДТГ, НАЗХГ	2018-01-05	31-12-2021	Тийм
8	Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл	Нийслэлийн ЗДТГ, НАЗХГ	30/4/2019	31/12/2021	Тийм
9	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл	Нийслэлийн ЗДТГ	2019	2021	Тийм
10	Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл	Нийслэлийн ЗДТГ	2020-06-26	2023-07-14	Тийм
11	Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл	Нийслэлийн ЗДТГ	2018-01-01	2020-01-01	Үгүй



Бодлогын баримт бичигт нийцсэн байдал

№	Санхүүжүүлэгч байгууллага	Төслийн нэр	ТАХ нь дараах шаардлагыг хангасан байна			
			Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод, төлөвлөлтөд нийцсэн эсэх	Монгол улсын дунд хугацааны хөгжлийн бодлогод, төлөвлөлтөд нийцсэн эсэх	Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан эсэх	Салбарын хөгжлийн бодлогод уялдсан эсэх
1	ЖАЙКА ОУБ	УБХАБХЧБТ-3	Нийцсэн	Нийцсэн		
2	ХБНГУ-ын Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ), ШХА (SDC)	Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл үе шат II	Алсын хараа-2050: Зорилт 6.4.	Монгол улсын Ногоон хөгжлийн бодлого: Стратегийн зорилт 1.3.1.2.	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр: 3.5.4.	Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого: 3.2.5.4, 3.2.5.5, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого: 2.2.4, 2.2.5, 2.2.6.
3	АХБ	Гэр хорооллын нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл	9.3.22.		6.1.2.	
4	АХБ, Уур амьсгалын ногоон сан, Өндөр технологийн сан	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	3.2.	3.2.	3.7.9.	
5	АХБ	Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл	Тийм. I үе шатын 5 дугаар заалт	Тийм. Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.6	Тийм. 6.1.9.	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр 3.1.1